



СЕКЮРИТИЗ
ҮЦК

ГАДААД ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2022.02.21-2022.02.25



ГАДААД ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2022.02.28-ны байдлаар

АНУ	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	Он гарснаас хойш
DOW	33,472.00	-1.75%	-0.36%	-4.72%	6.15%
US500	4,279.24	-2.40%	-0.67%	-5.08%	9.85%
NASDAQ	13,694.62	-2.87%	-0.52%	-7.58%	3.88%
Европ					
GB100	7,489.00	3.91%	-0.32%	0.26%	15.52%
DE40	14,567.00	3.67%	-3.16%	-5.77%	5.66%
FR40	6,752.00	3.55%	-2.56%	-3.29%	18.40%
IT40	25,773.00	3.60%	-2.77%	-3.18%	12.80%
ES35	8,487.00	3.51%	-1.20%	-1.55%	3.18%
Ази					
JP225	26,365.00	-0.42%	-1.88%	-2.21%	-10.98%
SHANGHAI	3,447.00	-0.12%	-1.50%	0.26%	-3.18%
CSI 300	4,562.00	-0.26%	-1.90%	-1.89%	-16.10%
SHANGHAI 50	65.00	-0.36%	-2.84%	-1.88%	-19.33%
CH50	14,622.64	-0.60%	-3.00%	-2.79%	-20.79%
SENSEX	55,842.00	2.41%	-3.44%	-2.51%	13.73%
Эрчим хүч					
WTI газрын тос	96.56	5.43%	4.96%	11.64%	59.23%
Брэнт газрын тос	102.15	4.31%	7.18%	14.54%	60.53%
Байгалийн хий	4.58	2.37%	3.45%	-1.95%	65.07%
Шатахуун	2.81	3.11%	2.20%	10.18%	44.86%
Нүүрс	239.00	-0.10%	2.80%	4.92%	180.85%
Түүхий эд					
Алт	1,910.52	1.15%	0.27%	6.77%	10.84%
Мөнгө	24.31	0.19%	1.60%	8.59%	-8.27%
Зэс	4.48	0.25%	0.11%	3.72%	8.88%
Бонд					
	Өгөөж				
АНУ	1.90	0.0678	-0.04%	0.12%	0.46%
Англи	1.49	0.0230	0.10%	0.28%	0.66%
Швейцар	0.32	0.0590	0.04%	0.34%	0.60%
Испани	1.14	0.093	-0.11%	0.39%	0.81%
Португал	1.11	0.0360	0.01%	0.50%	0.78%

ГАДААД ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ



Эх сурвалж: Business Insider

- Өнгөрсөн 7 хоногт АНУ-ын их зах зээлийн үнэлгээтэй компаниудын индекс буурч, дунд болон бага зах зээлийн үнэлгээтэй зах зээлийн индексүүд илүү тогтвортой байлаа.
- "Украин болон Оросын хурцадмал байдал үргэлжлэх хандлагатай байгаа тул Японы Nikkei 225 индекс 2 хувиар уналаа"
- Даваа гарагийн өглөөний арилжаагаар Ази, Номхон далайн орнуудын хувьцааны ханш уналттай нээгдэж, хөрөнгө оруулагчид Украиныг тойрсон нөхцөл байдлыг ажигласаар байна.

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Геополитикийн хямралаар хөрөнгийн зах зээлд залруулгын уналт (correction) явагдаж байна.

Өнгөрсөн 7 хоногийн Пүрэв гарагт ОХУ Украин улс руу гэнэтийн дайралт хийснээр хөрөнгийн зах зээлд ихээхэн уналт үзүүлж барууны орнууд ОХУ-д нэмж эдийн засгийн хоригууд тавив.

Тэдгээр хоригууд дундаас онцлоход олон улсын банкны гүйлгээний SWIFT үйлчилгээг ОХУ-д зогсоох мөн Европ ОХУ-аас байгалийн хий импортлон авахаа болих шийдвэр гаргав.

ОХУ нь таваарын үйлдвэрлэл болон экспортын томоохон улсуудын нэг юм. Европын байгалийн хийн нийт хэрэглээний 40%, газрын тосны 25%-ийг ОХУ дангаараа нийлүүлдэг.


Энэхүү нийлүүлэлт зогссоноор эрчим хүчний үнэ ханш өсөж инфляцыг цаашид нэмэгдүүлэх хүчин зүйл болж магадгүй байна.

Геополитикийн хямрал, хурдтай өсөж буй инфляц, Төв банкнаас бодлогын хүүг нэмж магадгүй зэрэг таамгууд нь хөрөнгийн зах зээлийг 1 сарын 3-ны оргил үеэс 12% унахад нөлөөлсөн байна.


Шинжээчдийн үзэж байгаагаар энэ 3 сарын Холбооны Нөөц Сангийн (ХНС) бодлогын хүү нэмэгдэх мэдээг тодорхой болтол хөрөнгийн зах зээл савлагаатай байхаар байна.

Харин Украины дайн, ОХУ-д тавьсан хоригууд нь олон улсад тодорхойгүй байдал үүсч байгааг авч үзэн ХНС-г өмнө таамаглаж байсан 0.5%-иас харьцангуй багаар өсгөж магадгүй гэж харж байна.


ОХУ-аас байгалийн хий импортолдог хэмжээ



S&P 500



US Interest rate



Source: International Monetary Fund


ОЛОН УЛСЫН БОНДЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ-ын 10 жилийн хугацаатай засгийн газрын үнэт цаас



АНУ-ын 10 жилийн хугацаатай засгийн газрын үнэт цаас 2 сарын 25-ны байдлаар 1.9860 хүрч 0.25 хувиар өссөн нь өнгөрсөн жилийн 2 сараас хойших хамгийн өндөр өсөлт байлаа.

Германын 10 жилийн хугацаатай засгийн газрын үнэт цаас



Германын 10 жилийн хугацаатай засгийн газрын үнэт цаас 2019 оноос хойш анх удаа эерэг өгөөж өгөх төвшинд хүрэв.

ОЛОН УЛСЫН БОНДЫН ЗАХ ЗЭЭЛ

Японы 10 жилийн хугацаатай засгийн газрын үнэт цаас



Японы 10 жилийн хугацаатай засгийн газрын үнэт цаас энэ жил 0.17 хувь өсөж 0.20 хувийн өгөөжтэй болсон нь сүүлийн 6 жилд тохиогоогүй өсөлт байлаа.

Шинжээчдийн үзэж байгаагаар АНУ-ын төв банк бодлогын хүүгээ энэ жил 3 сарын 16-аас эхлээд 4 удаа өсгөж магадгүй гэж таамаглаж байна.

Шинжээчид 3 сард бодлогын хүүг 0.5 хувиар өсгөх магадлал 67 хувь байгаа гэж үзэж байгаа бол энэ жилдээ нийт 1.25 хувиар өсгөх магадлал 75 хувь бий гэж үзжээ.

Канадын төв банкныг өнгөрсөн жил 5 удаа өсгөнө гэж төсөөлж байсан бол одоо 6 удаа өсгөх тухай мэдэгджээ. Харин Английн төв банк 4 удаа нэмнэ гэж байсан бол он гарснаар 5 удаа нэмнэ гэж төсөөлж байна.

ОЛОН УЛСЫН ВАЛЮТЫН ЗАХ ЗЭЭЛ

Америк доллар

Америк доллар 2021 оны 6 сараас хойш зогсолтгүй өссөн бөгөөд шинэ он гарснаар төв банк бодлогын хүүгээ өсгөхтэй холбоотой цаашид нэмэгдэх хандлагатай байна.




Евро

Евро өнгөрсөн оны 12 сараас хойш 1.13 америк доллар хавиар байсан бол энэ 2 сард Украин, Орос улсын нөхцөл байдал, Европын төв банк 7 сард бодлогын хүүгээ 0.5 хувиар өсгөнө гэсэн таамаг зэргүүдээс шалтгаалан 1.10 америк доллар хүртэл унаж магадгүй гэж шинжээчид харж байна.



Юань

БНХАУ-ын юань сүүлийн 5 жилд үзэгдээгүй өсөлт үзүүлсэн боловч цагаан сарын өмнөхөн бага зэрэг унасан. БНХАУ-ын засгийн газрын баримталж буй бодлого нь эргэлтэд байгаа юанийн нөөцийг ихэсгэхээс гадна бодлогын хүүгээ бууруулж юанийн ханшийг унагаснаар экспортыг нэмж эдийн засгаа сэргээх санаатай тул цаашид ч өсөж магадгүй.



Иен

Японы иен 2 сарын сүүлээр 1 ам.доллар 115 иен хүрсэн нь 2017 оноос хойших хамгийн их уналт юм. Барууны орнууд ОХУ-д эдийн засгийн хориг тавьсантай холбоотой эрсдэл багатай хөрөнгө оруулалт хийхийг хүссэн өнөө үе иений ханш тогтворжиход нөлөөлжээ. Японы төв банкны ТУЗ-ийн гишүүн Тояаки Накамура эдийн засгаа сэргээхийн тулд сул мөнгөний бодлого баримтлахаа саяхан дахин мэдэгдсэн. Түүний энэхүү мэдэгдэл нь бусад орны төв банкуудаас хамгийн сул байр суурийн нэг юм. Энэ нь цаашид Японы иенийг нэмж унах дохио болж өгч байна.

